

**Өргөн нэвтрүүлгийн үгэн болон
урсдаг мэдээллийн форматад тавих
шаардлага**

MNS 6607 : 2016



1. Хамрах хүрээ

Энэ стандартаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн дамжуулах үгэн болон урсдаг хэлбэрийн мэдээлэл, түүний суурь зурвасын дэлгэц дээр илэрхийлэгдэх байдалд тавих шаардлагыг тогтоосон. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгууд болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид мөрдөнө.



2. Нэр томьёо, тодорхойлолт

- Энэ сандартад дараахь нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

2.1 үгэн болон урсдаг мэдээлэл

дэлгэцийн доогуур нэмэлт байдлаар, суурь зурвас дээр гаргах үг, үсэг, тоо зэрэг тэмдэгтүүдээр илэрхийлсэн бичвэр

2.2 суурь зурвас

үгэн болон урсдаг мэдээллийг харуулах талбар



3. Суурь зурвасын дэлгэц дэх хэмжээ, байршил

- Нэвтрүүлгийн үеэр мэдээлэл дамжуулах суурь зурвас нь дэлгэцийн доод хэсэгт байрлах бөгөөд дан болон давхар байж болно. Суурь зурвасын дэлгэц дэх харагдах байдлыг 1 ба 2-р зурагт үзүүлэв.



Суурь зурвас нь дэлгэцийн өндрийн 5%, 10%, 15%, 20%-тай тэнцүү байх бөгөөд нийт зурвасын өндөр нь дэлгэцийн $\frac{1}{5}$ буюу 20%-иас хэтрэхгүй байна.

MNS 6607:2016



1-р зураг - Дан суурь зурвасын дэлгэц дэх байршил



Нэвтрүүлгийн үеэр мэдээлэл дамжуулах давхар суурь зурвасуудын дээд эгнээний зурваст дэлгэцээр гарч буй үндсэн мэдээллийн дэд гарчиг, оролцогчийн нэр, албан тушаал зэргийг бичсэн мэдээллийг /субтитр/ урсгахгүйгээр харуулах бөгөөд бусад мэдээллийг түүнд нөлөөлөхгүйгээр тусдаа зурваст харуулна. 2-р зурагт үзүүлэв.



2-р зураг - Давхар суурь зурвасын дэлгэц дэх байршил



- Суурь зурвас нь бусад өргөн нэвтрүүлгийн таних тэмдэг, тэмдэглэгээ, үгэн болон урсдаг мэдээлэлтэй давхцаж байвал түүнийг далдлахуйц, эсвэл утгыг алдагдуулахгүйгээр бүтэн байдлаар зэрэгцүүлэн гаргахуйц хэмжээтэй суурь зурвасыг ашиглана.



4. Суурь зурвасын өнгө

Телевизийн техникт ашигладаг суурь өнгөнөөс үзэгчдийн нүдний хараанд тохирсон өнгийг өөрийн брэндбүүкд нийцүүлэндараахь 5 үндсэн өнгөний кодоос сонгож хэрэглэнэ. Үүнийг 3-р зурагт үзүүлэв.

Улаан	#FF0000	RGB (255, 0, 0)
Хөх	#0000FF	RGB (0, 0, 255)
Хар	#000000	RGB (0, 0, 0)
Цэнхэр	#96d7ec	RGB (150, 215, 236)
Цагаан	#FFFFFF	RGB (255, 255, 255)

3-р зураг - Суурь зурвасыг сонгох 5 өнгө

ТАЙЛБАР:RGB гэдэг нь Red /Улаан/, Green /Ногоон/, Blue /Хөх/ буюу гэрлийн дисперсийн үзэгдлээс хугарч гарч ирсэн үндсэн өнгө бөгөөд эдгээр 3 өнгөнөөс бусад өнгийг гаргаж авна.



5. Суурь өнгө болон бичвэрийн өнгөний зохицол

5.1. Үзэгчдэд хялбар уншигдахуйц байдлаар дараахь 5 өнгөний зохицлоос сонгож хэрэглэнэ.

№	Суурь болон суурь зурвас		Бичвэр	
	Өнгө	Код	Өнгө	Код
1	Улаан	RGB 255/0/0	Цагаан	RGB 255/255/255
2	Хөх	RGB 0/0/225	Цагаан	RGB 255/255/255
3	Хар	RGB 0/0/0	Цагаан	RGB 255/255/255
4	Цэнхэр	RGB 150/215/236	Хар	RGB 0/0/0
5	Цагаан	RGB 255/255/255	Хар	RGB 0/0/0

5.2Бусад өнгөний зохицлыг дээрх 5 өнгийн кодоод үндэслэн гаргаж хэрэглэнэ.



6. Мэдээллийн үсгийн фонт, хэмжээ

- Урсдаг болон үгэн мэдээллийн тэмдэгтүүд нь Microsoft Windows үйлдлийн системийн Arial, Verdana фонтын 15-18 хэмжээтэй байна.



7. Баримтлах хэл зүйн дүрэм

- Бичвэрийг орчин цагийн Монгол хэлний зөв бичих дүрэм болон Монгол Улсын Төрийн хэлний зөвлөлөөс журамласан журмын дагуу ойлгомжтой, хураангуй хэлбэрээр бичнэ.



8. Мэдээллийн бүтэц, урсах хурд болон чиглэл

- Нэг мэдээллийн агуулгыг 8 хүртэлх үгтэй өгүүлбэрт багтаана. Бичвэр нь баруунаас зүүн тийш урсах чиглэлтэй байх бөгөөд урсан өнгөрөх хурд нь үзэгч уншиж гүйцэхүйцээр, нэг минутад 275 тэмдэгт буюу 55 үгнээс хэтрэхгүй байна.



9. Мэдээллийн эхлэл, төгсгөл

Дараалан урсаж буй өөр утга бүхий мэдээллүүдийг мэдээллийн эх сурвалжийн нэр, түүнийг төлөөлөх цахим хаяг, мэдээлэл дамжуулан хүргэж байгаа телевизийн алба, нэгж, хөтөлбөрийн нэр хаяг зэргийг ашиглан хооронд нь зааглана. Тухайлбал, ...TV, www//....mn гэх мэт. Үүнийг 3-р зурагт үзүүлэв.



3-р зураг - Мэдээллийн эхлэл, төгсгөлийн зааглалт

